

Энэтхэгээс Төвдөд орж ирсэн Буддын шашинд Амдогийн Зонхов (1357—1419) шинэтгэл хийж, шарын шашинг (ламын шашин) үүсгэн дэлгэрүүлснээс хойш он цагийн хүрд эдүгээг хүртэл есөн жарныг элээжээ. Шарын шашны тэргүүн Далай лам гэж хэн болохыг мэдэхгүй монгол хүн ховор боловч Далай лам хэмээх цол чухам хэдийд бий болсон, Төвдийн шашны тэргүүн Далай ламд Монгол хүн тодорч байсан тухай болон ер нь Төвдийн 14 хувилгааны талаар сонсож дуулаагүй хүн байж болох юм.

Төвдийн түүхэнд энэрлийн эх бурхан Жанрайсэгийн (Арьяабал) хойд дүр-Далай ламын хамгийн анхны дүрийг Зонховын шавь Гэндүндүб¹ хэмээн тэмдэглэсэн байдаг боловч Гандүндүбийн үед «Далай лам» цол хараахан бий болоогүй байжээ. Түмэдийн Алтан хан (Чингисийн 17 дахь үе) 1577 онд Төвдөөс шар малгайтны шашныг дэлгэрүүлэх зорилгоор шашны тэргүүн Содномжамцыг (1543—1589) Хөх хотод урин залахдаа анх түүнд «Далай лам» цол хайрласан байна². «Далай лам» цол ийнхүү Төвдийн шашны гурав дахь тэргүүн Содномжамцын үед бий болж улмаар он цагийн эргэлтэд Төвдийн шашны тэргүүнд тодорсон хувилгаан бүрийг өргөмжилдөг албан ёсны цол болон уламжилжээ. «Далай лам» цолын «далай» нь Монгол үг бөгөөд «лам» нь төвдөөр номын дээд багш гэсэн утгыг илэрхийлнэ. Төвдүүд Далай ламаа Содномжамцын өмнөх шарын шашны хоёр тэргүүн Гэндүндүб (1391—1475), Гэндүнжамц (1475—1543) нараас эхлэн тоолох ёс буй.

Өнгөрсөн түүхийн урт хугацаанд тодрон гарч ирсэн 14 Далай ламын нэгээс бусад нь төвд хүн байсан бөгөөд харин IV Далай лам Ёндонжамц (1543--1589) Монголоос тодорсон³ Чингисийн удмын нэгэн байлаа.

Хувилгаанаар тодруулах ёсыг Төвдөд Гажүдба буюу зарлигийн үндэстний Гарам багшийн үеэс (он цагийн тооллоор бол Монголын Юань гүрний үеэс) бий болсон хэмээн үздэг боловч, зарим түүх бичигт Гэлүгван буюу шар малгайтны шашны П Далай лам Гэндүнжамц, IV Банчин богд Лувсанчойжижанцан нарын үеэс уламжлал эхэлсэн хэмээн тэмдэглэсэн байдаг.⁴ Далай ламын хувилгаан дүрийг тогтсон нарийн ёс горимыг баримтлан таалал төгссөний дараа жилээс тодруулах ёслол хийнэ. Мэргэн төлөгчид өдөр судар тохируулан зурхайн аргаар Далай ламын хойт дүр байгаа газрыг тодорхойлдог, түүний дагуу засгийн газраас томилсон эрлийн хэсэг хойт дүрийг хайж олно. Дараа нь хойд дүрд тодрох хүүгээр талийгаачийн эдэлж хэрэглэж байсан эд юмсыг таниулж, урьд үеэ хэр зэрэг мэдэж байгаа эсэхийг шалгана. XIV Далай лам Данзанжамцын хувьд, урьдах Далай ламын эдэлж байсан таван зүйлээс гурвыг нь зөв таньсан гэдэг. Эхлээд нэг эрдэмтэй ламын хувцсыг солиулж өмсгөн хүүгийн гэрт оруулахад жаал хүү ламыг хармагц түүний хүзүүн дэх эрхийг Далай ламынх гэж шууд таньжээ. Түүний дараахь үйл явдлын тухай тэрээр дурсан, «Надад бараг адилхан 10 ширхэг хар эрх үзүүлсний нэгийг

Далай ламынх гэж зөн билгээрээ мэдэрсэн. Түүнчлэн надад хоёр дамар үзүүлэхэд бага дамрыг нь Далай лам туслахуудаа дуудахдаа хэрэглэдэг байсныг таньж заасан билээ» хэмээн намтартаа бичсэн байдаг.⁵ Дээрх олон сорилын эцэст хойт дүрээ Далай ламд өргөмжлөн арслант ширээнд суулгах их ёслол үйлддэг ажээ. Хамаг амьтныг хамгаалах сахилтай энэрлийн бурхан-Жанрайсэгийн хойд дүрийг тодруулахад ийнхүү нарийн зурхайн аргад тулгуурлан гойд няхуур шинждэг тул төвдүүд элдэв эргэлзээ, үл итгэх байдал гарах ёсон үгүй хэмээн үзэж, тодорсон Далай ламдаа үнэнхүү сэтгэлээр сүжиглэн биширдэг амой.

Ингээд уншигч та бүхэнд холбогдох материал ашиглан* Төвдийн шашны тэргүүн - Далай ламын 14 хувилгаан дүрийг харуулахдаа, манай Монголын түүхийн аль нэг үетэй ямар нэг хэмжээгээр холбоотой байсан Далай лам Содномжамц, IV Далай лам Ёндонжамц, V Далай лам Агваанлуvsанжамц, XIII Далай лам Түвдэнжамц, XIV Далай лам Данзанжамц нарын тухайд тогтож өгүүлэх нь зүйтэй болов уу гэж үзнэм.

I Далай лам Гэндүндүб

Монголын хуучин тооллын VII жарны цагагчин хонин жил буюу 1391 онд Зангийн Сажагийн (Цайвар шороот) Шовдад гэдэг газар төржээ. 20 настайдаа дээд Төвдөд очин шарын шашныг үндэслэгч Зонховыг шүтэж шавиар орсон байна. Тэрээр VII жарны улаагчин туулай жил буюу 1447 онд Дашлхүмбэ хийдийг бариулж, шашны гол том сургууль болох учир шалтгааны ухааны Цаннид дацанг нээв. Дашлхүмбэ хийд нь одоо Төвдийн шарын шашны 4 том хийдийн нэг билээ. I Далай лам Гэндүндүб 84 наслахдаа 5 боть зохиол бичсэн бөгөөд VIII жарны хөх морин жил буюу 1474 онд Дашлхүмбэ хийдэд таалал төгсчээ.

II Далай лам Гэндүнжамц

VIII жарны улаан бичин жил буюу 1476 онд Зангийн Данагюл (Хар морьтын орон) хэмээх газар төрсөн байна. Гэндүнжамц 11 насандаа сахил хүртэн хувраг болж, эхлээд Дашлхүмбэ хийдэд, хожим нь 1494 оноос Брэвэн хийдэд шавилан суув. Тэрээр шашны ухаанд төгс суралцах хүсэлдээ хөтлөгдөн төв Төвдөөр удаан хугацааны турш мөргөл үйлдэж явсан бөгөөд 43 настайдаа Брэвэн хийдийн тэргүүн хамбын суудалд суужээ. Эрдэм мэдлэгээр олонд алдаршсан Гэндүнжамцад зориулж 1518 онд Хятадын хаан Брэвэн хийдэд Галдан-побран буюу Төгс баясгалан ордонг бариулсан гэдэг. Далай лам Гэндүнжамц IX жарны хар бар жил буюу 1542 онд нас нөгцжээ. Гэндүнжамц 67 наслахдаа 3 боть зохиол бичсэн байна.

III Далай лам Содномжамц

IX жарны харагчин туулай жил буюу 1543 онд дээд Төвдийн Лүн хэмээх газар мэндэлжээ. Ш Далай лам Монголд шарын шашныг дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн хүний нэг билээ.

Монголын феодалуудын дотроос хамгийн хүчирхэг нөлөөтэй байсан Түмэдийн Алтан хан шарын шашны тусламжтайгаар бүх Монголыг эрхэндээ оруулан захирах бодлого баримталж, Хөх нуурт цэрэглэн орсныхоо дараа 1577 онд Төвдөөс Содномжамцыг хүндэтгэн залжээ. Бөө мөргөлийг орхин шарын шашныг авах болсонтой холбогдуулан хийсэн их ёслол дээр Алтан хан Содномжамцыг бүх шарын шашны толгойлогч хэмээн өргөмжилж «Оройн дээд очир дарь Далай лам»

цол өргөсөн ба Содномжамц Алтан ханд «Номын хүрд эргүүлэгч сэцэн хан» цол хайрлажээ. Содномжамц ийнхүү Алтан хантай холбоо тогтоож байсан явдал санамсаргүй хэрэг биш байв. Төвдөд Зонховын шарын шашинтан, Гарамын улааны шашинтан харгалдан тэмцэлдэж байсан тухайн цагт Содномжамц улааны шашинтны эсрэг тэмцэлдээ Монголын феодалуудын ивээл түшгийг хүсч байжээ. Түүнчлэн Хөх нуурын төвд, тангуд, уйгур нарыг байн байн довтолж байсан Монголын феодалуудын довтолгоо, тухайлбал, Алтан ханы довтолгоог холдуулах давхар зорилго хадгалж байлаа.

Алтан хан шарын шашинд орж нэр алдар нь ихээхэн түгж ирэхэд Монголын бусад феодалууд мөн дагалдан дууриаж эхэлжээ. Халхын ноёдын нэг Абтай 1577 онд өөрийн биеэр Алтан хааны нийслэл Хөх хотод очин Далай лам Содномжамцтай учирч шарын шашныг Халхад дэлгэрүүлэхээр харилцан хэлэлцэж тохирсон ба Далай лам түүнд хан цол хайрлажээ. Тухайн үеийг хүртэл Халхад хан цолтой хүн байсангүй.⁶ Содномжамц лам Монголын феодалуудтай холбоо тогтоохын зэрэгцээ тэднээр дамжуулан Мин улсын засгийн газартай холбоо тогтоохыг мөн зорьж байлаа. Алтан ханыг нас нөгчихөд Ш Далай лам хоёр дахь удаагаа Монголд хүрэлцэн очоод Мин улсын хааны явуулсан элчийг хүлээн авч хааны залснаар очихоор завдан байгаад X жарны шар хулгана жил буюу 1588 онд таалал төгсчээ.

IV Далай лам Ёндонжамц

X жарны шарагчин үхэр жил буюу 1589 онд Монголд төржээ. Ш Далай лам Содномжамц Монголд нас барсан явдал түүний хойт дүрд Монгол үндэстний нэгэн тодроход түлхэц болсон болов уу. Алтан ханы ач, Сүмэрдайчин хунтайжийн хүү Ёндонжамцыг Төвдийн нөлөө бүхий 2 мэргэн төлөгч Чойжин Найдан, Чойжин Цэдэв нар Далай ламын хойт дүрээр тодруулсан болой. Монголчууд Ёндонжамцыг нэг талаар нас бага хэмээн цааргалан, нөгөөтэйгүүр, Монголд шарын шашныг дэлгэрүүлэхэд түүний нөлөөг харгалзан Цастын орон (Төвд руу явуулахаас түдгэлзсээр 1604 онд 15 нас хүрэхэд нь сая алс холын аян залуулжээ. Ёндонжамцыг Төвдөд очсоны дараа Брэвэн хийдийн тэргүүн хамбаар өргөмжлөв. IV Далай лам X жарны улаан луу жил буюу 1616 онд нас сүүдэр 28 зооглох ахуйд Сэра хийдэд насан өөд болжээ. Халхын Цахар ноён түүний чандрууг хадгалах мөнгөн суврага босгож Брэвэн хийдийн Галдан-побран ордонд тавиулсан гэдэг. Тухайн үед Монголчуудын дунд Монголоос тодорсон Далай лам Ёндонжамцын амийг төвдүүд бүрэлгэсэн тухай гэхдээ бүр гэдсийг нь хонь гаргаж буй мэт хүйлж алсан тухай яриа тархсаныг Г. Ц. Цыбииков Түүвэр зохиолдоо тэмдэглэсэн байна.⁷

V Далай лам Агваанлуvsанжамц

X жарны улаагчин могой жил буюу 1617 онд дээд Төвдийн Жонжа (одоогийн Шаньнань) гэдэг газар төржээ. Лувсанжамц 6 настайдаа анх IV Банчин богд Лувсанчойжид (1570--1662) шавь орж, 1637 онд 20 насандаа гэвшийн дамжаа барьсан байна. V Далай ламын үед Төвдөд шар болон улааны шашинтны тэмцэл улам ширүүсч, улааны шашинтны эсрэг тэмцэлдээ тэрээр ойрадуудыг нэлээд түшиглэж байлаа. Далай ламын хүсэлтээр ойрадын Гүш хааны цэрэг Төвдөд орон улааны шашинтныг дарсны дараа 1642 онд V Далай лам Агваанлуvsанжамц төр шашныг хослон барих болсныг зарлан тунхаглах их ёслол болжээ. Гэвч хэрэг дээрээ Гүш хаан төрийн хэргийг гартаа ав-

сан байв. Гүш хааныг нас барсны дараа түүний гурван үехүү Даян, ач Пунцаг далай хан, гуч Лхацан нар Төвдийн төрийн хэрэгт нэлээд нөлөө бүхий хүмүүст тооцогдож байлаа. Өгүүлэн буй үед Төвдийн хэрэг явдалд чухал үүрэг гүйцэтгэж байсан өөр нэг хүн бол V Далай ламын шавь Дэсэр Санжаажамц юм. Шашин болон улс төрийн чамгүй боловсролтой Дэсэр Санжаажамц Төвдийн тусгаар тогтнолыг хамгаалах мөн өөрийн эрх мэдлээ удаан хугацаанд хадгалах зорилгоор Далай ламын нас нөгчсөнийг 10 гаруй жил чандлан нууцалж түүний өмнөөс шашин төрийн хэргийг явуулж байжээ. Тэрээр Ойрадын Галдантай нууц харилцаа тогтоон Галдангийн Манжийн эсрэг ил тэмцлийг дэмжиж байсан удай ламын бодлогыг үргэлжлүүлэн «Умард ба Дорнын хөршүүдтэй» уян хатнаар зохицон харилцаж байв.

Төвдүүд, V Далай лам Агваанлуvsанжамцыг Төвдийн түүхэнд, маш их зүйл хийсэн төрийн зүтгэлтэн, номын их багш хэмээн машид бишрэн хүндэтгэсээр иржээ. Тэрээр өдгөөг хүртэл сүндэрлэсээр буй сүрлэг Будалинг бариулах ажлыг эхэлж амьд сэрүүн ахуйдаа Цагаан ордонг дуусган 1653 онд Брэвэн хийдээсээ шилжин суужээ. Харин Будалины Улаан ордонг Дэсэр Санжаажамц бариулж дуусгасан байна. V Далай лам их номын хүн байсныг түүний бичиж үлдээсэн 25 боть зохиолоос мэдэж болох юм. Түшээт хан Гомбодоржийн хүсэлтээр Нагаржунан «Эрдэнийн эрх» номоос үлгэр аван бичсэн түүний «Улаан сувдан эрх», наш нэртэй бүтээлүүдийнх нь нэг билээ. V Далай лам 62 насалж, XI жарны хар нохой жил буюу 1682 онд Будалин ордонд таалал төгсчээ.

VI Далай лам Цаянжамц

XI жарны харагчин гахай жил буюу 1683 онд Хамын Литэн хэмээн газар мэндэлжээ. Дэсэр Санжаажамц Далай лам Агваанлуvsанжамцын нас барсныг нууцалж байхдаа түүнийг олж тусгайд нь хүмүүжүүлж байсан байна. Манжийн хааны шахалтаар V Далай лам өөд болсон нь аргагүй илрэх тэр цагт сая 1697 онд Цаянжамцыг 15 настайд нь VI Далай ламаар тодруулсан аж. Тухайн үед Төвдийн дотоодод улс төрийн байдал тогтворгүй болж, гаднаас Манж, Монголын нөлөө ихэсч байсан цаг билээ. Лхацан энэ үед өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн VI Далай лам Цаянжамцыг буулгах бодлого баримталж байлаа. Цаянжамц Далай ламуудаас, хувраг ёсонд бүрэн ороогүй цорын ганц тэргүүн байв. Тэрээр яруу найргийг ихэд сонирхон оролдож авьяас билгээ сорьж байсан бөгөөд бүтээлд нь өвөрмөц хэмнэл бүхий утга уянга, хайр сэтгэлийн шүлэг зонхилох байр эзэлдэг. Цаянжамцын намтарт түүний амьдралын сүүлийн хэсгийг ихэд бүрхэг, олон янзаар бичиж тэмдэглэсэн байдаг. Заримд нь түүнийг Манжийн хааны урилгаар Бээжин рүү гарах замдаа Хөх нуурт ХП жарны улаан нохой жил буюу 1706 онд хорлогдсон гэж байхад, заримд нь 1746 он хүртэл олон газраар хэсүүчлэн явсаар Монголын Алаг шарын даваанд (Алшань) IV Далай лам Ёндонжамцын бариулсан сүмд таалал төгссөн мэтээр янз янзын хувилбараар бичсэн байдаг.⁸ Цаянжамцыг нас нөгчихөд Лхацан хан өөрийн санааг хэрэгжүүлэн түүний төрлийн хүн болох Ишжамцыг Далай ламд өргөмжилжээ. Харин Хөх нуурын ноёд үүнийг эсэргүүцэн Галсанжамцыг Далай ламд тодруулах сонирхолтой байлаа. Дотоодын хямралаас шалтгаалж Төвдөд 1706—1718 оны хооронд ийнхүү хоёр Далай лам байв. 1717 онд Ойрадын Цэрэндондов Төвдөд цэрэглэн орж Лхацан ханыг дарсны дараа Далай ламд Галсанжамцыг албан ёсоор өргөмжлөн зарлажээ.

VII Далай лам Галсанжамц

XШ жарны шар хулгана жил буюу 1708 онд Хамын Литэн хэмээх газар мэндэлжээ. Тэрээр төрийн хэрэг ялангуяа дотоодын үймээн самууныг дарахад биечлэн оролцож байсан байна. Мэдлэг боловсролоороо олонд хүндтэй Галсанжамцын бичиж үлдээсэн 8 боть зохиолд шившлэг, тарнийн ухааны талаар бичсэн зүйл багагүй байдаг ажээ. Тэрээр XШ жарны бар жил буюу 1758 онд 50 насандаа Будалин ордонд өөд болсон байна.

VIII Далай лам Жамбалжамц

XШ жарны шар бар жил буюу 1758 онд доод Төвдийн Товжил Лхайриган гэдэг газар төржээ. Түүний эх Пунцагпагма Ш Банчин богд Балдан-Ишийн дүү байсан бөгөөд Далай лам 1781 онд Манжийн хаанаас «алтан тамга» хүртсэн зэрэгт Банчин богдтой садан төрөл байсан явдал багагүй нөлөөлсөн гэж үздэг. VIII Далай лам 47 насандаа XI жарны хөх хулгана жил буюу 1804 онд Будалинд таалал Төгсчээ.

IX Далай лам Лүндэгжамц

XШ жарны хөхөгчин үхэр жил буюу 1805 онд Хамын Башцук хэмээх газар төрж, XIV жарны улаан хулгана жил буюу 1816 онд Будалинд нас баржээ. Тэрээр 14 Далай лам нараас хамгийн бага насалсан нь бөгөөд дөнгөж 11 хүрэх ахуйд насан өөд болсон ажуу.

X Далай лам Чүлтэмжамц

IX Далай ламын таалал төгссөн тэр жил Хамын Литэнд төрж, XIV жарны улаагчин тахиа жил буюу 1837 онд IV Далай лам Ёндон жамцын нэг адил нас сүүдэр 28 хүрэх үедээ ертөнцийн мөнх бусыг үзжээ.

XI Далай лам Хайдавжамц

Мөн жарны шар нохой жил буюу 1838 онд Гада хэмээх газар төрж, бас л бага залуудаа (18 насандаа) XIV жарны харагчин туулай жил буюу 1855 онд Будалин ордонд нас нөгчив.

XII Далай лам Пэрэнлэйжамц

XIV жарны улаан луу жил буюу 1856 онд төрөөд 20 нас хүрэлгүй 1875 онд Будалин ордонд хорвоогоос хальсан байна. Түүнийг хор өгч алсан тухай ам дамжсан яриа бий. Ер нь урьдах гурван Далай ламын үхэл ч мөн эргэлзээтэй ажээ.

XIII Далай лам Түвдэнжамц

XV жарны улаан хулгана жил буюу 1876 онд Төвдийн зүүн өмнөд хэсэгт төржээ. XIII Далай ламын амьдарч байсан үе нь нэг талаас Манж Чин улсын Төвд дэх нөлөө суларч, нөгөө талаас англичуудын санаархал улам хүчтэй болж байсан үе билээ. Чухам тийм нөхцөл байдалд Төвдийн шашны тэргүүн XIII Далай лам шашнаасаа улс төрийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож байлаа. Энэ нь тухайн үеийн Төвдийн нийгмийн байдлаас шалтгаалж байснаас гадна Далай ламын хувийн сонирхолтой мөн холбоотой байв. Тэрээр Манж Чин улсын засгийн газраас Жао Эрцэний цэргийн хүчийг Төвдөд оруулахад мөн Английн цэрэг Лхас руу дайрахад хоёр ч удаа гадаад оронд зугтан

гарахдаа хаант Оросоос тусламж гуйх зорилго агуулж байсны зэрэгцээ Төвдийн өөртөө засан тохинох эрхийг бусад орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагаа явуулж байжээ. Хаант Оросоос тусламж гуйхад Далай ламын итгэлтэй 10 шавийн нэг болох буриад монгол Лувсан Агваандорж их үүрэг гүйцэтгэж байсан ба 1898—1913 оны хооронд нийтдээ 7 удаа Орост очин зуучилж байсан байна.⁹

Түвдэнжамц Монголд ирсэн хоёр дахь Далай лам бөгөөд 1904 оны 10-р сараас 1906 оны 4-р сар хүртэл Их хүрээнд байхдаа Богд гэгээн Жабзундамбатай хэд хэдэн удаа нууцаар уулзаж байжээ. Төвдийн 14 Далай ламын нэгд Монгол хүнд тодорч байсан лугаа адил Монголын шарын шашны тэргүүн найман Богд гэгээний зургаад нь төвд хүн тодорч байв. Тэдгээрийн нэг нь VIII Богд гэгээн Жабзундамба хутагт билээ. Тэрээр 1870 онд Лхаст Далай ламын нэг шадар түшмэлийн гэрт төрсөн ба 4 настайд нь Халхаас зориуд элч илгээн төрөл төрөгсдийн хамт хүрээнд залж авчирсан түүхтэй.

1913 оны 1-р сарын 11-нд Кунлунь-д Монгол Төвдийн харилцан хоёр талын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн найрамдлын гэрээ байгуулахад¹⁰ Төвд, Монголын шашин нэг, түүнчлэн Монголын төр шашны хэргийг төвд гаралтай хүн барьж байсан түүхэн нөхцөл байдал зохиох нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Төвдийн шашны тэргүүн, улс төрийн зүтгэлтэн ХШ Далай лам Түвдэнжамц XVI жарны харагчин тахиа жил буюу 1933 онд (Монгол улсын олноо өргөгдсөн 23-р онд) 57 насандаа Будалин ордонд насан өөд болсон байна.

XIV Далай лам Данзанжамц

XVI жарны хөхөгчин гахай жил буюу 1935 (Монгол улсын олноо өргөгдсөн 25-р онд) 7-р сарын 6-нд Төвдийн зүүн хойд хэсэгт Тагчер хэмээх газар жирийн нэгэн малчны гэрт төржээ. Данзанжамцыг 4 насанд нь Далай ламын арслан ширээнд залж өргөмжилсөн байна. Тэрээр 12 наснаас ном хаялцах сургууль эхэлж, Билэг баримидын 30 ботиос Сэнгэ бадра мөн V Далай ламын ботиудаас (сумбум) сонгон үзээд, 24 насандаа дом тавьж, 25 насандаа учир шалтгаанаар 30, дундаж үзлээр 15, билэг баримид номхотгол, абидармаар 35 эрдэмтэн ламд шалгалт өгөн гэвшийн дамжаа барьж лхаарамба цол хүртжээ. XIV Далай лам ихэнхдээ номын сургаалийн утга учрыг тайлбарлаж ном зохиол бичсэн нь олонтаа. Тэрээр «Нигүүлсэхүйн тухай бясалгал», «Миний эх орон миний ард түмэн», «Төвдөд дээдийн ном дэлгэрсэн түүх ба билгийн нүд нээгдсэн нь», «Дундад үзлийн түлхүүр ба Төвдийн буддизм» зэрэг 20 орчим зохиол бичсэн¹¹ их номын хүн төдийгүй улс төрийн томоохон зүтгэлтэн болохыг та бүхэн мэднэ. 1959 оны 3-р сард Төвдөд гарсан зэвсэгт бослогын үеэр 100 мянгаад төвдүүдийн хамт Энэтхэгт дүрвэн гарч, 30 гаруй жил Энэтхэгийн Химачал Прадеш штатын Драмсалад суух болсноос хойш улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож Төвдийн тусгаар тогтнолын асуудлыг байнга хөндөн тавьсаар иржээ. Өнгөрсөн хугацаанд дэлхийн 34 оронд 78 удаа айлчлал хийсний дотор Монголд 1979, 1982 онд 2 удаа ирсэн билээ. Өдгөө нас сүүдэр 56 шүргэж буй Далай лам ийнхүү дэлхийн өнцөг булан бүрт айлчлан эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд бие сэтгэлээ зориулан явахдаа уламжлалт буддын шашны их хөлөгний сургаалиас, аливаа хүн сэтгэлээ элдэв буруу зүйлээс (уур хилэн, шунал тачаал, үзэн ядахуй, атаа жөтөө найдангүй буюу бардамнал зэрэг) номхотгон ариусгаж, амьтай бүхэн зовлонг бус амьдрах аз жаргал эрмэлзэх ижил эрхтэй гэдгийг гүнээ ухаарч чадваас энэ нь улмаар улс түмэн харилцан бие биеэ ойлголцож дэлхий нийтийн өмнө тулгараад буй

асуудлыг хүчирхийллээс бусад арга замаар шийдвэрлэхэд тус дөхөм болох ёстойг номлон айлдаж байна. XIV Далай лам Данзанжамцыг 1989 оны 10-р сарын 5-нд дэлхийн улс түмнүүдийн хооронд энх тайвныг бэхжүүлэхийн төлөө олон улсын Нобелийн шагналаар шагнажээ.

¹ Я. Ханчжан «Дала ламачжуан», (Далай ламын намтар), Б., 1984 3-р тал, «Сизан байти вэньда». (Төвдийн талаархи 100 асуулт, хариулт) Б., 1988, 12-р тал

² «Занзу шилю» Төвд үндэстний түүх, Б., 1985 207-р тал БНМАУ-ын түүх тэргүүн боть, УБ., 1966, 453-р тал

³ Я. Ханчжан мөн ном 25-р тал

⁴ «Занзу шилю» Б., 1985, 207-р тал

* Төвдийн шашны тэргүүн 14 Далай ламын тухай бичихдээ: «БНМАУ-ын түүх» тэргүүн боть УБ., 1966, дэд боть УБ., 1968, Я. Ханчжан «Дала ламач жуан, Б., 1984: ГЦ. Цыбиков Избранные турды Новосибирск 1981; Сизан шияо» Б. 198 (Төвдийн түүхийн товч); И. А. Бэдделл «Ламаизм» Лондон 1967 «Занши луньвэнь сюань зун цзяоци» (Төвдийн асуудлаархи онолын өгүүллүүдийн түүвэр-шашин тэргүүн, дэд боть (Сючан хот 1985; Ц. Дамдинсүрэн, А. Лувсандэндэв «Мянган жилийн харьцуулсан хүснэгт(Орос Монгол толь-ийн хавсралт УБ., 1969; «Зансюе яньцзю Вэньцзи» Төвд судлалын өгүүллийн эмхэтгэл Б., 1985; Л. С. Савицкий «Цаньян Джамцо», «Песни, приятные для слуха» М., 1983, Цяньян цзащо цзи ци цингэ яньцзю» Лхас., 1985 (Цаянжамц түүний уянгын дууны талаархи судалгаа) зэрэг ном, хэвлэл ашиглав.

⁵ Н. Доржготов «Нинж нигүүлсэхүй сэтгэл» (Ертөнц сонин 1990. ҮП. 11., N 3)

⁶ БНМАУ-ын түүх тэргүүн боть 455-р тал

⁷ Г. Ц. Цыбиков мөн зохиол 143-р тал

⁸ Л. С. Савицкий мөн зохиол 28—35-р тал

⁹ «Зансюе яньцзю Вэньцзи» 134-р тал

¹⁰ Мөн зохиол 144-р тал: Hollis s Liao of the Tibetan independence movement Issues and studies Vol 25 N 4 April 1989 p 97–110

¹¹ His Holiness the XIV Dalai Lama of Tibet Dharamsala 1989 p 11